



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/483

Ховд

Цэргийн штабын бэлэн байдлыг дээшлүүлэхэд
шаардагдах хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Дайчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 31 дүгээр зүйлийн 31.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний Жанжин штабаас удирдан зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар ангитай хамтран явуулах "Оператив тактикийн хээрийн сургууль"-д оролцох Батлан хамгаалах газар, орон нутгийн цэргийн отряд, сумангийн бие бүрэлдэхүүний хээрийн хувцас, сургуульд шаардагдах материал хэрэгсэл, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг дээшлүүлэх зардалд нийт 25 000 000 төгрөг /хорин таван сая/-ийг хавсралтын дагуу гаргаж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах зардлыг "Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт"-ын 5.20-д заасан "Цэргийн штабын бэлэн байдлыг дээшлүүлэх" арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал /Т.Мягмардорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Зарцуулсан төсөв хөрөнгийн талаарх тайлан мэдээ, нэхэмжлэхийг бүрдүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Бадрал/, Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА 

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дүгээр сарын 14-ний өдрийн
А/483 дугаар захирамжийн хавсралт



ЦЭРГИЙН ШТАБЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ
ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Шаардагдах материал хэрэгслийн нэр	Нэг бүрийн үнэ	Тоо /ширхэг/	Бүгд үнэ /төгрөг/
1	Батлан хамгаалах газрын бие бүрэлдэхүүний хээрийн хувцас /зуны/ офицер	125 000	40	5 000 000
2	Орон нутгийн цэргийн отряд, сумангийн бие бүрэлдэхүүний хээрийн хувцас /зуны/ байлдагч	121 000	100	12 100 000
3	Оператив тактикийн хээрийн сургуульд шаардагдах материал хэрэгслийн зардал	3 660 000	-	3 660 000
4	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг дээшлүүлэх	4 240 000	-	4 240 000
Нийт				25 000 000

-oOo-